



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 494

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 07-01-001/55, 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 07-01-001/56 дугаар дүгнэлтээр тогтоогдсон, 6 нэрийн, нийт 77,025,617.50 (далан долоон сая хорин таван мянга зургаан зуун арван долоон төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 51,229,775.16 (тавин нэгэн сая хоёр зуун хорин есөн мянга долоон зуун далан таван төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан барилга байгууламжийн доорх Завхан аймгийн Улиастай, Алдархаан суманд байрлах газар эзэмших эрхийг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээж, нөхөн сэргээх, зориулалтын дагуу ашиглах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

137006063
26-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 10 дугаар сарын 12 ны өдрийн
 17/Х дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬА ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
 ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон, бүртгэсэн он	Хэм жиж нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Амралтын байр (3 ширхэг)	1995/2018	ор	2	554,205.83	1,662,617.50	1,246,963.36	415,654.14
2	Конторын барилга	2006/2018	м2	2515	72,373,000.00	72,373,000.00	48,036,242.26	24,336,757.74
3	Наралгааны байр	2009	м2	301	1,040,000.00	1,040,000.00	461,500.31	578,499.69
4	Бут, сөөг	2009	ш	13	10,000.00	260,000.00	252,777.05	7,222.95
5	Дулааны шугам	2009	метр	1545	50,000.00	1,000,000.00	729,167.18	270,832.82
6	Цэвэр бохирын шугам	2009	метр	2154	46,000.00	690,000.00	503,125.00	186,875.00
	Нийт дүн					77,025,617.50	51,229,775.16	25,795,842.34